

“ШҮҮХИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ БА ЦАХИМЖИЛТ” ОЛОН УЛСЫН БАГА ХУРЛЫГ НЭЭЖ ХЭЛСЭН ҮГ

/2025 оны 06-р сарын 16/



Энд хуран чуулсан эрхэм хүндэт зочид, хурлын оролцогч та бүхний өглөөний амар мэндийг айлтгая.

Дэлхий даяар эрх зүйт ёс, хүний эрхийг дээдэлсэн үндсэн хуульт ардчиллын хувьд нэг талдаа олон талбарын сорилт, нөгөө талдаа эрчтэй хөгжил, хувьслын боломж зэрэгцэж байна. Мэдээллийн технологийн хөгжил, “глобал цахимжилт” эдгээр сорилт, боломжийн аль алийг нь шүүхийн салбарт авч ирснийг энэхүү 2 өдрийн хуралдааны сэдвийн төвд байхаар төлөвлөсөн. Цахим технологи дэлхий даяар, салбар бүрд хүчтэй нөлөө үзүүлж буйг бид мэднэ. Эдийн засгийн салбарт: банкны

хэрэглээ, онлайн худалдаа, аялал жуулчлалын цахим үйлчилгээ гэхэд олон улсад 25-84%-ийн хооронд цахимжсан байна. Түүнчлэн,

- Боловсролын салбар дахь цахим үйлчилгээний санхүүжилт 10 жилийн өмнөхөөсөө хоёр дахин нэмэгдэж, онлайн сургалтын платформд бүртгэлтэй хэрэглэгчийн тоо 5 жилийн дотор 400 гаруй хувиар өсжээ.
- Интернэтээс эрүүл мэндийн мэдээлэл эрэлхийлэх хэмжээ 62.4%; Цахим эрүүл мэндийн салбарын эдийн засгийн үнэлгээ 2020 онд 216 тэрбум а.доллар байсан бол 2022 онд 334 болж, 2025 онд 657 тэрбумд хүрэх төлөв ажиглагдаж байгаа судалгаа байна.
- Нийгмийн харилцааны хувьд: олон нийтийн цахим сүлжээний хэрэглээ хөгжингүй орнуудад 70.4%, Азийн хөгжиж буй орнуудад 87.2%-тай байгаа ба цаашид ч өсөх үзүүлэлттэй байгаа зэрэг олон тоон мэдээллийг дурдаж болно.

Энэхүү глобал цахимжилтаас төрийн үйлчилгээ ч хоцроогүй. Тухайлбал, Засгийн газрын байгууллага, нэгжээс мэдээлэл авах явдал хөгжингүй орнуудад 55.1%, хөгжиж буй Азийн орнуудад 20.9%; Засгийн газрын байгууллага, нэгжтэй цахимаар харилцах явдал мөн хөгжингүй орнуудад 54.5%, хөгжиж буй Азийн орнуудад 25.6%-ийн үзүүлэлттэй байна. Дэлхийн банкны мэдээллээр 2021 онд судалгаанд хамрагдсан 120 улсын шүүхээс цар тахлын үед 77 нь цахим технологийг тодорхой хэмжээнд нэвтрүүлсэн байна.

Шүүхийн цахим шилжилтэд хиймэл оюун онцгой анхаарал татаж шүүхийн процесс, шийдвэр, үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, улмаар хүний эрхийн хамгаалалтад өндөр нөлөө үзүүлж байгаагаас шалтгаалан салбарын стратеги төлөвлөлтөд зайлшгүй харгалзах ёстой хүчин зүйл болжээ. Үүнтэй зэрэгцэн мэдээллийн нууцлагдсан, бүрэн бүтэн, ашиглах боломжтой байдал буюу кибер аюулгүй байдлын асуудлыг шүүхийн салбарт зөвхөн технологийн түвшинд бус, эрх зүйн орчин, байгууллагын ба нэгж албан хаагчийн менежментийн түвшинд нарийвчлан анхаарах шаардлага нэгэнт тодорхой болжээ.

Гэвч цахим технологийн хэрэглээ, үр нөлөө нь нөгөө талдаа, байгалийн нөөц, эрчим хүчний хэрэглээг үлэмж нэмэгдүүлж, хүн төрөлхтний ирээдүйд санаа чилээх шаардлага үүсгэж буй. Тухайлбал, 2018-2022 оны хооронд дэлхийн томоохон 13 дата төвийн цахилгааны

хэрэглээ хоёр дахин нэмэгдсэн байна. Харилцах утсанд гэхэд **1960** оны байдлаар байгалийн 10 элемент хэрэглэдэг байсан бол 1990 онд 27, 2021 онд 63 болж өссөн. Улмаар 2050 онд гэхэд бал, литийн давс зэрэг бодисын хэрэгцээ 500%-иар нэмэгдэх төлөвтэй байгаа.

Эдгээр хүчин зүйлийг шүүхийн тогтолцоонд харгалзаж, эдийн засгийн ноёрхлын эсрэг экологийн хамгаалалтыг эрх зүйн үүднээс хангах архитектурыг бүтээх үүднээс Энэтхэг, Шинэ Зеланд болон бусад улсын “Ногоон шүүх”-ийн туршлагыг харгалзах боломжтой.

Энэ мэт өндөр эрчимтэй хувьсаж буй хөгжил, сорилтын давалгаанд шүүх эрх мэдэл оновчтой бодлого хэрэгжүүлэх, үйл ажиллагааныхаа чанарыг тогтмол дээшлүүлж, “уламжлал, шинэчлэлийг хослуулж” явах шаардлага бидний өмнө тулгарч байна. Энэ утгаараа өнөөдрийн хуралдаан цаг үеэ олсон, онцгой ач холбогдолтой үйл явдал мөн.

Тиймээс хуралдааныг Монгол Улсын дээд шүүхтэй хамтран зохион байгуулж буй Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам, Төрийн департамент болон бүрэн эрхт элчин сайд ноён **Ричард Буанган** танд талархлаа илэрхийлье.

Монгол Улсаас сүүлийн 12 жилийн хугацаанд 200 гаруй (213) мэргэжилтэн “Конгрессын олон улсын манлайллын төв” (COIL)-ийн Нээлттэй дэлхий программд хамрагджээ. Энэхүү хоёр өдрийн хуралдааныг ч манлайлан зохион байгуулж буй “Конгрессын олон улсын манлайллын төв”-ийн хамт олон, Гүйцэтгэх захирал хатагтай **Жейн Саргус** танд мөн тухайлан талархлаа илэрхийлье. Түүнчлэн Монгол Улсаас хамтран оролцож буй Шүүхийн Ерөнхий Зөвлөл, Шүүхийн академийн хамт олон та бүхний цаашдын ажилд амжилт хүсье.

Хуралдаанд алс холоос үнэтэй санал, туршлагаа хуваалцахаар эх орныг минь зорьж ирсэн **Америк, Армен, Эстони, Узбекистан, Казакстан, Серби, Индонез, Киргиз, Молдова** улсын хүндэт зочид, мэргэжил нэгт нөхөд та бүхэнд талархаж байна. 2 өдрийн арга хэмжээ өндөр үр дүнтэй болно гэдэгт эргэлзэхгүй байна, хурлын арга хэмжээнд амжилт хүсье.

Та бүхэнд баярлалаа.

—oOo—

**OPENING REMARKS AT THE INTERNATIONAL CONFERENCE
“JUDICIAL INDEPENDENCE AND COURT DIGITALISATION”**

/June 16th, 2025/



I extend my warmest greetings to distinguished guests and conference participants gathered here today.

Within the sphere of constitutional democracy that upholds the rule of law and human rights, we are witnessing, on the one hand, challenges emerging across multiple domains, and on the other hand, dynamic opportunities for development and transformation arising simultaneously. The advancement of information technology and the wave of global digitalization have brought both these challenges and opportunities into the judiciary—a focus that has been deliberately placed at the center of this two-day conference agenda.

We are all well aware of the profound impact that digital technologies are having across various sectors around the world. For example, in the economic sector, the rate of digitalization in banking services, online commerce, and digital tourism now ranges internationally between 25% to 84%.

Furthermore:

- In the education sector, funding for digital services has doubled over the past decade, and the number of users registered on online learning platforms has increased by over 400% in just five years.
- In the healthcare sector, an average of 62.4% of people now search for health-related information online. The economic value of the global e-health sector was estimated at USD 216 billion in 2020 and USD 334 billion in 2022, with forecasts suggesting it could reach USD 657 billion by this year.
- In the sphere of social interaction, usage of social media platforms stands at 70.4% in developed countries and 87.2% in developing countries across Asia—figures that continue to rise.

The impact of this wave of global digitalization has not bypassed public services either.

For instance:

- The proportion of citizens obtaining information from government agencies via digital means stands at 55.1% in developed countries and 20.9% in developing Asian nations.
- The proportion of citizens communicating with government agencies online is 54.5% in developed countries and 25.6% in developing Asian nations.

According to data from the World Bank, during the COVID-19 pandemic, 77 out of 120 surveyed national court systems had adopted digital technologies to some degree by 2021.

In the digital transformation of the judiciary, artificial intelligence has become an area of particular focus—given its growing impact on enhancing judicial processes, the quality of decisions and services, and ultimately the protection of human rights. For this reason, AI must now be recognized as an essential factor to be addressed in sector-wide strategic planning.

At the same time, issues of cybersecurity—including confidentiality, integrity, and availability of information—must be addressed not only at the

technological level but also through the legal framework and through institutional and individual staff-level management practices within the judiciary.

However, the use and growing impact of digital technologies also bring another set of concerns: a significant increase in natural resource and energy consumption, raising sustainability challenges for the future of humanity. For example, between 2018 and 2022, electricity consumption in the world's 13 largest data centers doubled. The number of elements used in telephones made in 1960 was 10, rising to 27 elements for telephones made in 1990. In 2021, a smartphone contained as many as 63 of the elements in the periodic table. By 2050, the global demand for materials such as graphite and lithium salts is projected to increase by 500%.

In light of these factors, the judicial system must also take into account the need to develop a legal architecture that balances economic dominance with the imperative of environmental protection. In this regard, international experiences such as the "Green Courts" of India, New Zealand, and other countries may offer valuable insights.

Amid this rapidly evolving wave of development and challenges, the judiciary must adopt sound policies and continually improve the quality of its operations—striking an appropriate balance between tradition and innovation. In this sense, today's conference is both timely and highly significant.

Therefore, I would like to extend my sincere gratitude to the Embassy of the United States of America, the U.S. Department of State, and Ambassador Mr. Richard Buangan, for co-organizing this conference in partnership with the Supreme Court of Mongolia.

Over the past 12 years, more than 200 Mongolian professionals (213 to be precise) have participated in the Open World Program of the Congressional Office for International Leadership (COIL). I would also like to offer my special thanks to the team at COIL, and in particular to Executive Director Ms. Jane Sargus, for their leadership in organizing this two-day event.

I wish continued success to the Judicial General Council for their valuable contributions and future efforts.

I also warmly welcome and thank our esteemed guests and colleagues from the United States of America, Armenia, Estonia, Uzbekistan, Kazakhstan, Serbia, Indonesia, Kyrgyzstan, and Moldova, who have traveled great distances to share their insights and experiences with us.

I am confident that this two-day conference will yield highly productive outcomes. I wish you all great success in your discussions and deliberations.

Thank you.

—oOo—